



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2014 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 1574

Улаанбаатар хот

Үнэт цаас бүртгэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 83.1 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06-р сарын 11-ний өдрийн 201 тоот тогтоол, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8.10.11-р заалт, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Бүртгэлийн журам”-ын 23.6, 23.9-р заалт, “Орхонбулаг” хувьцаат компанийн 2014 оны 08-р сарын 11-ний өдрийн 14/04 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу хийсэн бүртгэлийн шалгалтын тайлан 2014 оны 10-р сарын 03-ны өдрийн захирлын зөвлөлийн хурлын санал, дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. “Орхонбулаг” хувьцаат компанийн гаргасан нийт 284,063 /хоёр зуун наян дөрвөн мянга жаран гурав/ ширхэг хувьцааг “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлээс хассугай.
2. Холбогдох мэдээллийн санд өөрчлөлт оруулж, “Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанид хадгаламжаас хасах мэдэгдэл хүргүүлэхийг Үйл ажиллагааны газар /М.Энхтуяа/-т үүрэг болгосугай.
3. “Орхонбулаг” хувьцаат компани зохион байгуулалтын хэлбэрээ өөрчилж хязгаарлагдмал хариуцлагатай компани болж, “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн бүртгэлээс хасагдсан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Зах зээлийн хөгжлийн газар /Ж.Мягмарсүрэн/-т үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР

Маягт 5

**ҮНЭТ ЦААСНЫ ТӨЛБӨР ТООЦОО,
ХАДГАЛАМЖИЙН БАЙГУУЛЛАГАД
ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ**

Хэнд: “Үнэт цаасны төлбөр тооцоо,
төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-д

№ 412

Огноо: 2014.10.08

ҮЗҮҮЛЭЛТ	ҮНЭТ ЦААС БҮРТГЭЛЭЭС ХАСАХ	
Мэдэгдлийн агуулга:	Үнэт цаас бүртгэлээс хасах тухай	
Үндэслэл:	Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06-р сарын 11-ний өдрийн 201 тоот тогтоол, МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 08-ны өдрийн №44 тоот тушаал	
Санхүүгийн хэрэгсэл: /хувьцаа, өрийн хэрэгсэл гэх мэт/	Хувьцаа	
Үнэт цаасны нэр:	“Орхонбулаг” ХК	
Үнэт цаасны код: /үсгэн, тоон/	OTL	
Үнэт цаасны төрөл: /энгийн, давуу эрхийн/	Энгийн	
Үнэт цаасны хэлбэр: /биет, биет бус/	Биет бус	
Нийт үнэт цаасны тоо: /ширхэг/	284,063	
Энгийн	тоо /ширхэг/	284,063
	хувь /%/	100%
Олон нийтийн Эзэмшил	тоо /ширхэг/	284,063
	хувь /%/	100%
Төрийн эзэмшил	тоо /ширхэг/	-
	хувь /%/	-
Үнэт цаасны нэрлэсэн үнэ: /төгрөг/	100	
Үнэт цаасны нийт үнийн дүн: /төгрөг/	28,406,300	

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Д.АНГАР